

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тус хуулиар Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, 20 минутын Үндэсний хорооны дарга нарыг Засгийн газрын бүрэлдэхүүнээс хассан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжиж байгаа тул төсвийн зохицуулалт хийх шаардлага үүсээд байна.

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний 5 сард дунджаар 72 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 39 хувиар унаад байна. Улмаар нийт экспорт 2025 оны эхний 5 сард 5.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 15 хувь буюу 931 сая ам.доллороор, төсвийн нийт орлого 11.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11 хувь буюу 1.3 их наяд төгрөгөөр буураад байна. Мөн эдийн засгийн өсөлт 2023 онд 7.4 хувь, 2024 онд 4.9 хувь байсан бол 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж буураад байна. Экспорт, төсвийн орлого буурч, эдийн засгийн өсөлт саарсны улмаас 2025 онд нэгдсэн төсвийн орлого тасрахаар байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгож байна.

Улмаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Эдийн засгийн бодит өсөлтийг 2025 онд 5.5 хувь, инфляцыг 9.5 хувь, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнийг 90 их наяд төгрөг, төсвийн орлого 30,209.9 тэрбум төгрөг байхаар тооцооллоо. Төсвийн суурь зарлагыг тооцохдоо төрийн байгууллагуудад төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөхгүй байх замаар цалингийн зардлыг бууруулах, мөн төрийн албанд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу хэвийн ажиллаж байгаа албан хаагчдын ажлын байрыг хадгалах зарчмыг баримталсан болно.

Хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа.

Тэнцвэржүүлсэн орлого: Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.

- **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл:** Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байна гэж заасан хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ:** Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байхаар тооцсон нь хуулийн шаардлагад нийцэж байна.
- **Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг 2025 онд ДНБ-ий 55 хувь, 2026 онд 50 хувь, 2027 онд 45 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн хуулийн шаардлагыг хангаж байна.